



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/71

Улаанбаатар хот

Цахим программыг туршилтын хугацаанд
ашиглах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2, 4 дүгээр зүйлийн 4.1.9, 13 дугаар зүйлийн 13.3, 13.6, 15 дугаар зүйлийн 15.5, Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/400 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар хүлээн авч, шийдвэрлэх, мэдээлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хүсэлтийг <https://tzmoh.gov.mn> хаягаар 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн туршилтын хугацаанд программ болон цаасаар хүлээн авч, шийдвэрлэхийг Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар (Ж.Энхзул)-т үүрэг болгосугай.

2.Цахимаар тусгай зөвшөөрлийн хүсэлт шийдвэрлэх болсонтой холбогдох мэдээлэл, сурталчилгааг байгууллагын сайтад байршуулах, сургалтыг зохион байгуулахыг Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар (Ж.Энхзул)-т даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Намхайноров)-т даалгасугай.

ДЭД ДАРГА, ДАРГЫН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ Д.УРАНЗАЯА



142022 01071